



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 071

Мандалговь

“Өвс тэжээлийн агуулах саравч засварлах”
ажил /Дэлгэрцогт сум/ гүйцэтгэгчийг сонгон
шалгаруулах Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Өвс тэжээлийн агуулах саравч засварлах ажил /Дэлгэрцогт сум/”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Б.Түвшинбаяр (Аймгийн Засаг Даргын Тамгын Газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга)

Гишүүд: Ё.Дашням (Иргэний төлөөлөл)

Д.Даариймаа (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн)

Ө.Дугармаа (Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн зохицуулагч)

Нарийн бичгийн дарга: М.Бат-Эрдэнэ (Орон нутгийн өмчийн газрын ХАА хариуцсан мэргэжилтэн)

Хоёр. Үнэлгээний хороо байгуулагдсанаас хойш тендер шалгаруулалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Түвшинбаяр)-д даалгасугай.

Гурав. Тендер шалгаруулалттай холбогдолтой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (М.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ЭРДЭНЭСҮРЭН

48206027